



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/264

Улаанбаатар хот

Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/127 дугаартай “Үнэлгээний хороо байгуулах тухай” тушаалаар байгуулагдсан “Шар, цагаан будаг, будаг шингэлэгч, цацруулагч” нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга Б.Мөнхбаатар (Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө оруулалт, захиалагчийн албаны Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн) гэснийг Ч.Ганзориг (Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө оруулалт, захиалагчийн албаны Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн) гэж өөрчилсүгэй.

2.Бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбогдуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (С.Булганцэрэн)-нд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал), Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

3.Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендерт оролцоход үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ч.Ганзориг)-д даалгасугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА